



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 1/303

Номгон

Орчны бохирдлыг бууруулах, нийтийн эзэмшлийн
гудамж, зам, талбайн цэвэрлэгээг зохион байгуулах,
хог хаягдлын менежментийг сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1, 77 дугаар зүйлийн 77.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/69 дүгээр тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орчны бохирдлыг бууруулах, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулсугай. Үүнд:

1.1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээг сар бүр тогтмол зохион байгуулж хэвшүүлэх, хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах, хогийг ангилан ялгаж ачих нөхцөл, боломжийг бүрдүүлэх, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх

1.2. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохиромжтой цэгүүдэд хогийн савыг шинэчилж, засвар үйлчилгээг тогтмол хийх, тамхины цэг болон стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг байгуулж, төлөвлөлтийг оновчтой хийж, менежментийг сайжруулах;

1.3. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадлыг хэвшүүлж, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр бодит үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх

1.4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах чиглэлээр оролцоог нэмэгдүүлэх, сурталчилгаа, мэдээллийн ажлыг тогтмол зохион байгуулах

626010837

1.5.Төвлөрсөн хогийн цэгүүдийн хил хязгаар, одоогийн ашиглалтын байдлыг шалгах, стандартад нийцүүлэх, төвлөрсөн хогийн цэгийн төлөвлөлт, доторх авто замын нөхцөл болон ариутгал халдваргүйтгэл, бүртгэл мэдээллийг сайжруулах, хог дарж булах талбайг нэмэгдүүлэх

1.6.Сумын эрх бүхий албан тушаалтнууд хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрчимжүүлж, илэрсэн зөрчилд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, иргэн, аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээг тогтмол үзүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Бүх нийтийн гудамж талбайн цэвэрлэгээний ажлыг сар бүр зохион байгуулж аймгийн төвийн өнгө үзэмжийг нэмэгдүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга (М.Насанбат), холбогдох байгууллагын дарга нарт, Улсын болон орон нутгийн чанартай авто замын дагуу үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэх ажлыг яаралтай зохион байгуулж ажиллахыг Баянхонгор, Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр зөвлөмж, дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг улирал бүр нэгтгэн танилцуулахыг Байгаль орчны газрын дарга (Б.Бат-Өлзий)-д үүрэг болгосугай.

4.Үр дүнгийн талаарх тайланг хагас, бүтэн жилээр танилцуулахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

5.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



مجلس سید الشہداء

1206 ५७
०५ ३३
०५ ३३

2024

நினைவு

[illegible][illegible]

٦٠. مقدم و فوائدها ن و ششتمین. مقدم در توضیح هر توضیح. در هر دو :
 نهمین در توضیح ن و ششتمین. مقدم در توضیح هر توضیح. در هر دو :
 ٦١. مقدم در توضیح ن و ششتمین. مقدم در توضیح هر توضیح. در هر دو :

[illegible][illegible][illegible][illegible]

625010613

